




Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ний өдрийн А/92 тоот
тушаалын 2 дугаар хавсралт Маягт-8



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ
Дугаар А-U2024/13

Улаанбаатар

2024 оны 01 сарын 15-ны өдөр

Захиалагч байгууллага: ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗАР
Хэрэглэгчийн нэр: Ш.ЭНХТУЯА
Харилцах утас: 260182
Байршил: УБ хот, СБД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Юу Би Эйч
төв 8 давхар

Сувагчлалаар татах шилэн кабелийн хэрэгцээ:					
д/д	Кабель шугамын тасаг	Чиглэлийн нэр:	Сувагчлалын урт (м)	Худгийн тоо (ш)	Агаарын багана (ш)
1	32	"Энх тайван найрамдлын орд" -ны байрнаас Тагнуулын ерөнхий газар хүртэл	1508	20	

1. **Техникийн онцгой нөхцөл:** Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцөлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах, шилжүүлэх тохиолдолд уг барилга объектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.
2. **Техникийн үндсэн нөхцөл:**
- 2.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.
- 2.2 Худаг сувагчлалаар шинээр шилэн кабель суурилуулахдаа Монгол Улсын MNS 5207:2011, MNS 5278:2012, MNS 5317:2011 стандартуудыг мөрдөнө.
- 2.3 Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах нэгжид мэдэгдэн ажил эхлэх зөвшөөрөл авна.
- 2.4 Техникийн нөхцөлийн дагуу гүйцэтгэсэн ажлыг техникийн актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд түүнд гарах аливаа эрсдэл, гэмтэл саатлын хариуцлагыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.
- 2.5 Техникийн нөхцөлийн дагуу худаг сувагчлалын түрээсийн гэрээ байгуулна.
3. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**
- 3.1 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтран хяналт тавьж, угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.
- 3.2 Агаараар татсан шилэн кабелийг гүйцэтгэлээр нь гэрээ байгуулна.
- 3.3 Шилэн кабелийг худагт нөөц үлдээхгүй татах бөгөөд зөвхөн төгсгөлийн төхөөрөмж байрлуулах хэсэгт нөөц авах-ыг зөвшөөрнө.
- 3.4 Шинээр татсан кабельд биркийг /хаягжилт/ худаг бүрт болон төгсгөлийн төхөөрөмжид бүрэн хийсэн байх ба худагт кабелийн залгаа хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.

